# Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг 2022-2026 онд хөгжүүлэх стратеги

**А.Батсайхан**, Монголбанк, Төлбөр тооцооны газар, Бодлого зохицуулалт, үйл ажиллагааны хэлтсийн захирал

2022.06.22

# СТРАТЕГИ 2016-2020




Үндэсний төлбөрийн системийн стратеги 2016-2020 үндсэн зорилт:

- Төлбөрийн системийн эрх зүйн орчныг бүрдүүлэх
Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг 2017 онд батлуулж, 2018 оноос мөрдөж эхэлсэн

- Төлбөрийн системийн суурь дэд бүтцийг сайжруулах
Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд бүх системүүдийг шинэчилж эсвэл сольсон, шаардлагатай шинэ системүүд нэвтрүүлсэн

# СТРАТЕГИ 2022-2026

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙГ 2022-2026 ОНД ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

Монголбанк

## Стратегийн зорилго

Цахим төлбөр тооцоо давамгайлсан, найдвартай, аюулгүй байдлыг хангасан төлбөрийн систем, үр ашигтай, хэрэглэгч төвтэй төлбөрийн үйлчилгээг бий болгох

- 3 бүрэлдэхүүн хэсэг
- 9 зорилго
- 36 хэрэгжүүлэх арга хэмжээ

# ЗОРИЛГО # 1: ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ, ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БЭХЖҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** СЗХ-той хамтран банкнаас бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавих хяналт, шалгалтын уялдаа холбоог сайжруулах зорилгоор одоо мөрдөгдөж буй хуулиудад дүн шинжилгээ хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн барих;



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 05 дугаар сарын 31-ний өдөр — Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

Хэвлэх

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж**

Хэвлэх

2.1.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд үндэсний төлбөрийн системийн тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

Хэвлэх

3.1.Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд үйлчилнэ.

3.2.Хязгаарлагдмал хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа энэ хуульд хамаарна.

**4 дүгээр зүйл.Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд баримтлах зарчим**

Хэвлэх

4.1.Монгол Улсын үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1.1.үндэсний төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах;

4.1.2.үндэсний төлбөрийн системийн тогтвортой, тасралтгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангах;

4.1.3.төлбөр тооцоог үл саатуулах;

4.1.4.төлбөрийн эцэслэлт, төлбөрийн үл буцаагдах байдлыг хангах;

4.1.5.үндэсний төлбөрийн системийн эрсдэлийг зохистой удирдах;

Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах:

- Бусад хуультай уялдаа холбоог сайжруулах
- Шаардлагагүй зохицуулалт, хязгаарлалтыг хасах

(Жишээ: бутархай цахим мөнгөний хязгаарлалт)

# ЗОРИЛГО # 1: ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ, ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БЭХЖҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, системийн операторт зөвшөөрөл олгох, хяналт тавих үйл ажиллагааг цогцоор нь зохицуулсан нэгдсэн журам гаргах;

Нэгдсэн журам

- Төлбөрийн картын журам
- Цахим мөнгөний журам
- Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам
- Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам
- Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам
- Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам

# ЗОРИЛГО # 1: ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ, ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БЭХЖҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Санхүүгийн мэдээллийг банк, банк бус төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нар солилцон, харилцан ашиглах боломжтой нээлттэй банкны (open banking) үйлчилгээг дэмжсэн хууль эрх зүйн зохицуулалт бий болгох хэрэгцээ шаардлагыг судлах;






**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Төлбөрийн системтэй холбоотой авч буй тайлан мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг автоматжуулах;



# ЗОРИЛГО # 5: ҮТС-ИЙН ҮР АШИГТАЙ, АЮУЛГҮЙ, НАЙДВАРТАЙ, ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Банксүлжээ систем, ACH+, Картын нэгдсэн сүлжээтэй холбоотой мэдээлэл солилцох, санал хүсэлтэд хариулах зорилготой Оролцогчдын группийг албан ёсоор байгуулах;









# ЗОРИЛГО # 5: ҮТС-ИЙН ҮР АШИГТАЙ, АЮУЛГҮЙ, НАЙДВАРТАЙ, ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 6.** Валютын арилжааны төлбөр тооцооны эрсдэлийг үнэлэх зорилгоор өөрийн цахим арилжааны системээс гадуурх валютын арилжааны гүйлгээний төлбөр тооцооны зохицуулалт, дотоодын зах зээл болон хил дамнасан гадаад валютын гүйлгээний урсгал, корреспондент банкны харилцаанд дүн шинжилгээ хийх.



# ЗОРИЛГО # 7: ИННОВАЦИ, ЦАХИМ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Төлбөр тооцоо хийх зардал, хэрэглэгчийн зан төлөв, түүнийг өөрчлөх хүчин зүйлс зэргийг багтаасан цахим төлбөрийн хэрэглээний талаарх иж бүрэн судалгааг хийх. Судалгааны үр дүнд үндэслэн Монголбанк цахим төлбөрийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авах;

# ЗОРИЛГО # 7: ИННОВАЦИ, ЦАХИМ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 3.** Монголбанк нь 2024 он гэхэд үндэсний брэнд ₮ картыг EMV чип рүү бүрэн шилжүүлэхэд банкуудтай хамтран ажиллах;







I. СТРАТЕГИ

**II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

III. ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

# ЗОРИЛГО # 7: ИННОВАЦИ, ЦАХИМ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Төлбөрийн системийн нэгдмэл байдлыг хангах, зах зээл дэх өрсөлдөөн, инновацийг дэмжих зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн дансны дугаарлалт (IBAN), QR кодыг стандартчилах ажлыг гүйцэтгэх;






# ЗОРИЛГО # 8: ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨЛБӨРИЙГ ЦАХИМЖУУЛАХ АЖЛЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 1.** Цахим Монгол хөтөлбөрийг дэмжиж, E-Mongolia платформоор хийгдэж буй бүх төлбөрийг цахим хэлбэрээр тасралтгүй, үр ашигтай, аюулгүй байдлаар дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.** Цахим төлбөр тооцоог дэмжиж, цахим төлбөрийн хэрэгслээр бараа бүтээгдэхүүн худалдан авсан нөхцөлд татварын системд автоматаар бүртгэгдэн, НӨАТ-ын буцаан олголт хийх талаар судлах.






# ЗОРИЛГО # 9: ХИЛ ДАМНАСАН ТӨЛБӨР ТООЦООНЫ ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.** Олон улсын цахим худалдааны гарц, Монголын худалдаа үйлчилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг бий болгох үүднээс үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоо тогтоох, хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх;

stripe

WeChat Pay

PayPal

amazon pay

2CO 2CHECKOUT

# ЗОРИЛГО # 9: ХИЛ ДАМНАСАН ТӨЛБӨР ТООЦООНЫ ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 5.** Аж ахуйн нэгж, иргэд хил дамнасан гүйлгээ хийхэд тулгардаг, шимтгэл хураамж, хурд, ил тод байдал, хүртээмж, хууль эрх зүйн хязгаарлалт, төлбөрийн системийн дэд бүтэцтэй холбоотой гарч байгаа бэрхшээл, асуудалд дүн шинжилгээ хийх;

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа 6.** Дээрх дүн шинжилгээнд үндэслэн гарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.

# ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Хэрэгжүүлэх үе шат | Ойрын хугацаа – 1 жил | Богино хугацаа – 2-3 жил | Дунд хугацаа – 5 жилийн дотор |
|---|---|---|---|
| Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн оролцоо | Стратегийн хэрэгжилт | Төлбөрийн системийн шинэчлэлтэй холбоотой хэлэлцүүлэг | Хамтын ажиллагаа |

# ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Жил бүр**

- Хэрэгжилтийн явцын тайлан
- Төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах

**2024 он**

Дунд хугацааны иж бүрэн үнэлгээ

**2026 он**

Стратегийн хэрэгжилтийн эцсийн үнэлгээ

# Анхаарал тавьсанд баярлалаа

**Холбоо барих:** **А.Батсайхан**, a.batsaikhan@mongolbank.mn, 327510